**ДОРНОД АЙМАГ ДАХЬ<br>ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

***Дашбалбар сумын Цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит***

**Аудитын код:** ***ДОА-2021/28/СТА-ТШЗ***


| | | |
|---|---|---|
| | Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга | |
| | бөгөөд Тэргүүлэх аудитор: | Б.Болортуул |
| Цахим хуудас: www.audit.mn | Утас: 7058-4203 | Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn |
| Чойбалсан хот | Аудитын менежер: | И.Сэмжидмаа |
| 2021 он | Утас: 7058-4207 | Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn |
| | Аудитор: | Э.Нандинчимэг |
| | Утас: 7000-3775 | Цахим хаяг:khaanconsultingaudit@gmail.com |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| ДОА | Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| МУЕА | Монгол Улсын Ерөнхий аудитор |
| ДОА | Дорнод аймаг |
| ЗТХС | Зам тээвэр, хөгжлийн сайд |

## Агуулга

1. Төрийн аудитын санал, дүгнэлт ....3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан....5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ....9
3.Аудитын тайлан....10
3.1. Ерөнхий зүйл....10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ....10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт ....10
3.4. Материаллаг байдал ....11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ....11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт ....11
3.7. Шилэн дансны мэдээлэл....12
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....12
3.9. Аудитын илрүүлэлт....12
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил ....12
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд ....13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ....14

## 1. Төрийн аудитын санал, дүгнэлт

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000. Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.25 № 299

танай__________-ны №____________-т

ДОРНОД АЙМГИЙН ДАШБАЛБАР СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Л.ЦОГЗОЛМАА ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Дашбалбар сумын цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймгийн Дашбалбар сумын цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дорнод аймгийн Дашбалбар сумын цэцэрлэгийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө дүгнэгдээгүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

011020280

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **53,520,752.00** | **54,393,042.20** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 53,520,752.00 | 54,393,042.20 |
| **354** | **Хангамжийн материал** | 47,105,752.00 | 47,343,042.20 |
| 35420 | Аж ахуйн материал | 40,146,952.00 | 42,874,602.20 |
| 35450 | Барилгын засварын материал | 1,372,000.00 | - |
| 35460 | Хүнсний материал | - | 4,468,440.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 5,586,800.00 | - |
| 35600 | Мал амьтад | 6,415,000.00 | 7,050,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **288,745,425.36** | **1,014,340,520.38** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 288,745,425.36 | 1,014,340,520.38 |
| **392** | **Биет хөрөнгө** | 267,290,258.57 | 992,801,853.56 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 261,261,983.88 | 938,142,848.88 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (12,938,879.44) | (35,588,652.10) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 40,012,668.00 | 64,229,983.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (33,641,183.70) | (36,748,417.65) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 17,902,291.00 | 26,616,448.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (11,559,842.19) | (14,378,129.16) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 26,893,940.00 | 73,493,940.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (20,827,018.98) | (23,152,467.41) |
| 39217 | Ном | 186,300.00 | 186,300.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 21,455,166.79 | 21,538,666.82 |
| 39301 | Програм хангамж | 770,000.00 | 1,020,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (474,833.21) | (641,333.18) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 21,160,000.00 | 21,160,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **342,266,177.36** | **1,068,733,562.58** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **342,266,177.36** | **1,068,733,562.58** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 342,266,177.36 | 1,068,733,562.58 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 161,709,693.00 | 161,709,693.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 161,709,693.00 | 161,709,693.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 74,491,030.97 | 800,958,416.19 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 74,491,030.97 | 74,491,030.97 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 726,467,385.22 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 106,065,453.39 | 106,065,453.39 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **342,266,177.36** | **1,068,733,562.58** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **391,168,945.00** | **1,182,447,103.59** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **390,266,945.00** | **1,178,764,603.59** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 3,660,945.00 | 767,312,231.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 3,660,945.00 | 767,312,231.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,050,000.00 | 1,635,000.00 |
| 1200044 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | | 16,760,926.50 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Үхөрөнгө | 610,945.00 | 748,916,304.50 |
| **123** | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | 386,606,000.00 | 411,452,372.59 |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 350,446,000.00 | 398,222,372.59 |
| 123004 | Улсын төсвөөс орон нутгийн төсвөөс төвлөрүүлэх шилжүүлэг | 26,360,000.00 | 13,230,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **902,000.00** | **3,682,500.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 902,000.00 | 3,682,500.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 902,000.00 | 3,682,500.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **391,438,138.77** | **455,979,718.37** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **391,438,138.77** | **455,979,718.37** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 390,781,974.88 | 455,829,718.37 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 249,569,874.00 | 310,953,152.88 |
| 210101 | Үндсэн цалин | 188,474,190.00 | 242,753,395.72 |
| 210102 | Нэмэгдэл | 42,266,007.00 | 49,504,567.16 |
| 210104 | Урамшуулал | 18,829,677.00 | 18,695,190.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 32,335,966.61 | 38,257,966.12 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,077,566.61 | 27,228,729.12 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,564,800.00 | 2,548,707.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,051,600.00 | 2,289,938.62 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 512,900.00 | 987,935.65 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,129,100.00 | 5,202,655.73 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 23,207,871.00 | 20,555,270.99 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,940,573.00 | 4,680,572.61 |
| 210302 | Түлш, халаалт | 15,767,298.00 | 15,364,698.38 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,500,000.00 | 510,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 9,337,960.30 | 25,083,418.80 |
| 210401 | Бичиг хэрэг | 911,000.00 | 983,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,868,640.00 | 1,494,535.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 562,188.30 | 666,600.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 92,960.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,973,732.00 | 21,845,823.80 |
| **2105** | **Нормативт зардал** | 46,606,070.20 | 27,453,467.60 |
| 210502 | Хоол, хүнс | 46,366,770.20 | 27,453,467.60 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,332,120.00 | 784,400.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,332,120.00 | 784,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,185,500.00 | 420,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,025,500.00 | 260,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 160,000.00 | 160,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 25,828,612.77 | 32,322,041.98 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 95,000.00 | 1,154,800.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,550,700.00 | 100,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 24,182,912.77 | 31,067,241.98 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 656,163.89 | 150,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 600,000.00 | 150,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 600,000.00 | 150,000.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 56,163.89 | 33,979,637.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(269,193.77)** | **726,467,385.22** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(269,193.77)** | **726,467,385.22** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **377,708,000.00** | **448,286,009.59** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **377,708,000.00** | **448,286,009.59** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 350,446,000.00 | 411,840,600.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 350,446,000.00 | 411,840,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 902,000.00 | 2,854,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 902,000.00 | 1,625,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 26,360,000.00 | 33,591,409.59 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 26,360,000.00 | 33,591,409.59 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **377,708,000.00** | **448,286,009.59** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **377,708,000.00** | **448,286,009.59** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **377,051,836.11** | **414,156,372.59** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 249,569,874.00 | 308,592,719.00 |
| 210101 | Үндсэн цалин | 188,474,190.00 | 240,392,961.84 |
| 210102 | Нэмэгдэл | 42,266,007.00 | 49,504,567.16 |
| 210104 | Урамшуулал | 18,829,677.00 | 18,695,190.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 32,335,966.61 | 40,618,400.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,077,566.61 | 28,273,100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,564,800.00 | 3,086,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,051,600.00 | 2,497,530.62 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 512,900.00 | 1,039,833.65 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,129,100.00 | 5,721,635.73 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 23,207,871.00 | 20,555,270.99 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,940,573.00 | 4,680,572.61 |
| 210302 | Түлш, халаалт | 15,767,298.00 | 15,364,698.38 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,500,000.00 | 510,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 9,985,499.30 | 8,805,565.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 911,000.00 | 820,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,868,640.00 | 1,494,535.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 562,188.30 | 666,600.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 250,000.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,393,671.00 | 5,731,470.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 48,164,625.20 | 33,065,737.60 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 102,300.00 | - |
| 210502 | Хоол, хүнс | 46,089,325.20 | 32,440,737.60 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,973,000.00 | 625,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,052,000.00 | 443,900.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 902,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 3,150,000.00 | 443,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,378,000.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,378,000.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 6,718,000.00 | 820,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6,558,000.00 | 660,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 160,000.00 | 160,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,640,000.00 | 1,254,780.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,640,000.00 | 1,099,980.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **656,163.89** | **34,129,637.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 600,000.00 | 150,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 600,000.00 | 150,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 2,129.00 | 12,592,238.60 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,129.00 | 12,592,238.60 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 54,034.89 | 21,387,398.40 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 54,034.89 | 21,387,398.40 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 161,709,693.00 | 106,065,453.39 | 74,491,030.97 | 0.00 | 342,266,177.36 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | 0.00 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **161,709,693.00** | **106,065,453.39** | **74,491,030.97** | **0.00** | **342,266,177.36** |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | | 0.00 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | | 0.00 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | 0.00 |
| Тайлант үеийн үр дүн | | | | | 0.00 |
| **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **161,709,693.00** | **106,065,453.39** | **74,491,030.97** | **0.00** | **342,266,177.36** |
| **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **161,709,693.00** | **106,065,453.39** | **74,491,030.97** | **0.00** | **342,266,177.36** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **161,709,693.00** | **106,065,453.39** | **74,491,030.97** | **0.00** | **342,266,177.36** |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 725,638,885.22 | 0.00 | 725,638,885.22 |
| **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **161,709,693.00** | **106,065,453.39** | **800,129,916.19** | **0.00** | **1,067,905,062.58** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 321,279,700.00 | 324,580,700.00 | 447,126,000.00 | 411,452,372.59 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 321,279,700.00 | 324,580,700.00 | 447,126,000.00 | 411,452,372.59 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 320,679,700.00 | 324,430,700.00 | 446,971,200.00 | 411,302,372.59 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 249,572,500.00 | 249,569,900.00 | 308,631,900.00 | 308,592,719.00 |
| 210101 | Үндсэн цалин | 179,219,400.00 | 188,474,200.00 | 252,481,700.00 | 240,392,961.84 |
| 210102 | Нэмэгдэл | 40,691,100.00 | 42,266,000.00 | 37,406,000.00 | 49,504,567.16 |
| 210104 | Урамшуулал | 29,662,000.00 | 18,829,700.00 | 18,744,200.00 | 18,695,190.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 30,008,300.00 | 30,490,100.00 | 40,618,400.00 | 40,618,400.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,109,100.00 | 22,077,700.00 | 28,273,100.00 | 28,273,100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,051,600.00 | 2,564,800.00 | 3,086,300.00 | 3,086,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 205,600.00 | 205,600.00 | 2,469,100.00 | 2,497,530.62 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 512,900.00 | 512,900.00 | 617,300.00 | 1,039,833.65 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,129,100.00 | 5,129,100.00 | 6,172,600.00 | 5,721,635.73 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 23,210,000.00 | 23,207,900.00 | 34,841,500.00 | 20,555,270.99 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,700,000.00 | 5,940,600.00 | 7,370,000.00 | 4,680,572.61 |
| 210302 | Түлш, халаалт | 15,010,000.00 | 15,767,300.00 | 25,971,500.00 | 15,364,698.38 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,500,000.00 | 1,500,000.00 | 1,500,000.00 | 510,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 10,005,100.00 | 12,985,500.00 | 9,853,200.00 | 5,951,565.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 900,000.00 | 911,000.00 | 820,000.00 | 820,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,648,600.00 | 4,868,600.00 | 1,903,000.00 | 1,494,535.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 544,500.00 | 562,200.00 | 825,000.00 | 666,600.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 250,000.00 | 250,000.00 | 250,000.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | - | - | 92,960.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | - | 6,055,200.00 | 2,877,470.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 3,662,000.00 | 6,393,700.00 | | |
| **2105** | **Норматив зардал** | 2,075,300.00 | 2,075,300.00 | 49,877,500.00 | 33,065,737.60 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 102,300.00 | 102,300.00 | 75,000.00 | - |
| 210502 | Хоол, хүнс | - | - | 49,162,500.00 | 32,440,737.60 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,973,000.00 | 1,973,000.00 | 640,000.00 | 625,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,150,000.00 | 3,150,000.00 | 443,900.00 | 443,900.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,150,000.00 | 3,150,000.00 | 443,900.00 | 443,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,378,000.00 | 1,378,000.00 | 400,000.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,378,000.00 | 1,378,000.00 | 400,000.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,185,500.00 | 420,000.00 | 1,050,000.00 | 820,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,025,500.00 | 260,000.00 | 890,000.00 | 660,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 160,000.00 | 160,000.00 | 160,000.00 | 160,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 95,000.00 | 1,154,000.00 | 1,254,800.00 | 1,254,780.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 95,000.00 | 1,154,000.00 | 1,100,000.00 | 1,099,980.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 600,000.00 | 150,000.00 | 154,800.00 | 150,000.00 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | - | - | - | - |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | | | | |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | | | | |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 600,000.00 | 150,000.00 | 154,800.00 | 150,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 600,000.00 | 150,000.00 | 154,800.00 | 150,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 347,639,700.00 | 350,940,700.00 | 447,126,000.00 | 445,432,009.59 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 347,639,700.00 | 350,940,700.00 | 447,126,000.00 | 445,432,009.59 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 347,639,700.00 | 350,940,700.00 | 447,126,000.00 | 445,432,009.59 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл | |
|---|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | - | **3,682,500.00** | |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | - | **3,682,500.00** | |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | - | 3,682,500.00 | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | - | 3,682,500.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 3,682,500.00 | |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | - | 3,682,500.00 | |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 3,682,500.00 | |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 3,682,500.00 | |

# 3.Аудитын тайлан

## 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Дашбалбар сумын цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Л.Цогзолмаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-аас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Улаанбаатар хот дахь Хаан консалтинг Аудит ХХК-ийн аудитор Э.Нандинчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Дашбалбар сумын цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 04 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

## 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Дашбалбар сумын цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Эх оронч үзэл төлөвшүүлэх зорилтот жилийн хүрээнд өөрийн цэцэрлэгийн үзэл баримтлалын хүрээнд Хүүхэд бүр Үндэсний буриад хэл, ёс заншил / Буриад дуу шүлэг, аман наадам, уг гарвал, өвөг дээдсийн үе, буриадын түүхэн домог, үлгэр туульс г.м/ биет бус өв соёлоос суралцах, уламжлалт тоглоом наадгайгаар тоглож багаасаа төлөвших бахархалт зан үйлийг сургалтын хөтөлбөр, хүүхэд хөгжүүлэх өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой хэрэгжүүлсэн.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

## 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Дашбалбар сумын цэцэрлэгийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт дотоод аудитын алба 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Дашбалбар сумын цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.5 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 218,524.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар тооцон 4,370.4 мянган төгрөгөөр тооцлоо.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дашбалбар сумын цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 726,467.3 мянган төгрөгөөр буюу 3.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Бараа материал | 53,520.7 | 54393.0 | 872.3 |
| Үндсэн хөрөнгө | 368,187.2 | 1,124,849.5 | 756,662.3 |
| Үндсэн хөрөнгийн элэгдэл | (79,441.7) | (110,509.0) | (31,067.3) |
| **Нийт хөрөнгө** | **342,266.2** | **1,068,733.5** | **726,467.3** |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 161709.6 | 161709.6 | - |
| Хуримтлагдсан үр дүн | 74,491.0 | 800,958.4 | 726,467.4 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **342,266.2** | **1,068,733.5** | **726,467.3** |

Бараа материалын дансны үлдэгдэл 54,393.0 мянган төгрөг болж 872,3 мянган төгрөгөөр өссөн нь бараа материал, сургалтын хэрэгсэл авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,124,849.5 мянган төгрөг болж 756,467.3 мянган төгрөгөөр өссөн нь орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрээр 676,880.8 мянган төгрөгөөр барилга, 46,600.0 мянган төгрөгөөр нийтийн 00 болон бусад тоног төхөөрөмж хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Дашбалбар сумын цэцэрлэгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 791,278.1 мянган төгрөгөөр буюу 3 дахин өссөн байна. Энэ нь барилга байгууламж ашиглалтад орсонтой холбоотой.

Нийт зардал өмнөх оноос 64,541.6 мянган төгрөгөөр буюу 16.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл, хангамжийн материалын зардал бараа үйлчилгээний бусад зардлууд байна. Энэ нь цалин нэмэгдсэн, бараа материал зарлагадсан зэргээс шалтгаалсан байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 447,126.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 447,126.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн санхүүжилтийг 447,126.0 мянган төгрөгөөр баталсан байна.

### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 477,126.0 мянган төгрөгийг төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 411,840.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 33,591.4 мянган төгрөгийг санхүүжилт авч, нийт 445,432.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 412,452.4 төгрөгийг зарцуулж, улсын төсөвт буцаан 33,979.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 412,452.4 мянган төгрөг буюу 99.1 хувьтай байна,Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 350,211.2 мянган төгрөг буюу 84.9 хувийг эзэлж байна.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Өөрийн үйл ажиллагаанаас 3,682.5 мянган төгрөгийн орлого орсон байна. Үүнээс 832.3 мянган төгрөгийг хөгжим, 2,850.2 мянган төгрөгийг бараа материал бичиг хэргийн материалд зарцуулсан.

## 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд 143 мэдээлэл оруулснаас хугацаандаа оруулсан 137 мэдээлэл, хугацаа хоцорч 6 мэдээлэл оруулсан байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээ хийгдээгүй байна. Батлагдсан төсөв хэтрэлт хэмнэлтийн шалтгааны 470,657.0 мянган төгрөгийн мэдээллийг хугацаа хоцорч байршуулсан байна.

## 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаж байгаа, 1 төлбөрийн актыг төлж барагдуулсан.

## 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 17,554.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 17,554.7 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүллээ.

### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 17,554.7 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 17,554.7 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Худалдан авалтын үнийн гэрээний үнэ болон тендерийн үнийн саналтай харьцуулахад 1,353.4 мянган төгрөгийн зөрүүтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлсийн 2.6-д “төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх” гэсэн заалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

   Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2. Тайлант оны эцэст 6,771.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн тооллогыг хангалтгүй чанаргүй хийсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1 дэх “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.”, 12.2.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 12.2.2-т "эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед", УСНББОУС 1-Санхүүгийн тайлангийн толилуулгад нийцэхгүй, оршин байх, эрх ба үүрэг, үнэлгээ, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

   Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3. Тайлант хугацаанд гарсан зардлаас 9,430.3 мянган төгрөгийн зардлыг и-баримт цахим системд бүртгүүлээгүй нь СС-ын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрөх гэсэн тушаалыг бүрэн хангаж ажиллаагүй байна.

   Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

### 3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Хөрөнгийн тооллогыг чанартай бодитоор хийхгүй байгааг дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудалд авч үзлээ.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо: | Аудитын нэр: | Дорнод аймгийн Дашбалбар сумын Цэцэрлэг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит | Аудитын код: |
|---|---|---|---|
| 2021.02.25 | | | ДОА-2021/28/СТА-ТШ3 |
| Шалгагдсан байгууллагын нэр: | Дорнод аймгийн Дашбалбар сумын Цэцэрлэг | | Мянган төгрөг |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Жилийн эцсийн хөрөнгийн тооллогын тайлангийн дүнг хөрөнгийн дэлгэрэнгүй журналтай тулгахад бусад хөрөнгө 6,771.0 мянган төгрөгийн зөрүүтэй. Төмөр хашаа дансанд бүртгэлгүй байна. Бараа материалын дансанд 2,408.2 мянган төгрөгийн тавилга ширээ сандал, 309.0 мянган төгрөгийн ном бүртгэлтэй байна. | 6,771.0 | Албан шаардлага өгөх | Цэцэрлэгийн эрхлэгч Нягтлан бодогч | Л.Цогзолмаа О.Дуламсүрэн |
| 2 | Нийт 137 мэдээг хугацаанд нь оруулж, 6 мэдээллийг хоцорч оруулсан байна. Үүнд: 1. Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (Бүтэн жилээр,Хагас жилээр,Улирал бүр,Сар бүр) 12 сард мөнгөн дүн нь 470,657.0 мянган төгрөг 2. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (Тухай бүр) 11 сард 3. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр) 4. Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл (Бүтэн жилээр,Сар бүр) 11 сард 5. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг (Тухай бүр) 11 сард 6. Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр (Тухай бүр) 11 сард | 0.0 | Албан шаардлага өгөх | Цэцэрлэгийн эрхлэгч Нягтлан бодогч | Л.Цогзолмаа О.Дуламсүрэн |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3 | Нүүрс тээврийн Тэнгэр тэтгэх тал ХХК-тай гэрээ байгуулан нүүрс тээврийн ажил гүйцэтгүүлсэн байна. Ольхон ХХК-тай хүнс худалдан авах гэрээ хийсэн боловч 1,353.4 мянган төгрөгийн тендерийн үнийн саналд ороогүй бүтээгдэхүүний худалдан авсан байна. | 1,353.4 | Албан шаардлага өгөх | Цэцэрлэгийн эрхлэгч Нягтлан бодогч | Л.Цогзолмаа О.Дуламсүрэн |
| 4 | Төлбөрийн цахим системд шивэгдээгүй 9,430.3 мянган төгрөгийн и-баримт шивэгдээгүй байна.. | 9,430.3 | Албан шаардлага өгөх | Цэцэрлэгийн эрхлэгч Нягтлан бодогч | Л.Цогзолмаа О.Дуламсүрэн |
| **ДҮН** | | **17,554.7** | | | |